

**“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК – ИЙН ЗҮҮН ҮЙЛДВЭРИЙН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДЭСЛЭЛД ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ ГАРГАХ ШИНЭЧИЛЭН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН
ДААЛГАВАР**

2023 оны сарын өдөр

Улаанбаатар хот

1. Зураг төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"> • 2022.02.22-ны орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны албан даалгавар; • 2022.04.07-ны Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын албан тоотууд; <p>“Тавантолгой түлш” ХХК -ийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө</p>
2. Барилга байгууламжийн байршил	Төв аймаг, Сэргэлэн сум, 1 -р баг, Баян уулын баруун тал, “Тавантолгой түлш” ХХК -ын Зүүн үйлдвэр
3. Зориулалт, хүчин чадал	600тн/жил хүчин чадалтай “Таван толгой түлш” ХХК-ийн Зүүн үйлдвэрийн ТЭЗҮ-г дүгнэж үндэслэн хүчин чадлаар тооцож эргэн төлөгдөх хугацааг тодорхойлох
4. Үндэслэл	<ul style="list-style-type: none"> – “Таван толгой түлш” ХХК-ийн зүүн үйлдвэрийн 1,2-р цех 600,000 тн/жил хүчин чадалтайгаар 2020 оны 10 сарын 15-нд боловсруулагдсан ТЭЗҮ-д үнэлэлт дүгнэлт гаргах – 3-р цехийн 8тн/цаг-ийн 2 шугам бүхий нийт 16тн/цагын үйлдвэрийн хүчин чадлыг тооцоолон хамтад нь дүгнэлт гаргах – Цаашлаад 2023 онд төлөвлөсөн ажлуудыг үндэслэн нийт Зүүн үйлдвэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 1,2,3-р цехийн нийт хүчин чадлыг тооцож ТЭЗҮ боловсруулах
5. Боловсруулахад ашиглах материал	<p>Монгол улсын хуулиуд:</p> <ul style="list-style-type: none"> – Хот байгуулалтын тухай хууль – Барилгын тухай хууль – Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД/30.01.01/-ийн дагуу төлөвлөх – Үйлдвэрийн газрын барилга БНБД-31.20.11 – Үйлдвэрийн барилга БНБД 31-11-09 – Орон сууц, иргэний барилга БНБД – Төмөр замын сандарт MNS 6229:2010, – MNS 6060:2010, MNS 5833:2010 – Авто зам – Барилгын инженер геологийн ажил БНБД 11-03-02 – Зүүн үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл – Зүүн үйлдвэрийн 2021-2023 ны бүтээгдэхүүн үйлдвэрлэл – Нэмэлт шаардлагатай материал
6. Гүйцэтгэх ажил	<p>“Таван толгой түлш” ХХК-ийн зүүн үйлдвэрийн 2020 оны 10 сарын 15 өдрийн батлагдсан Техник эдийн засгийн үндэслэлд үнэлэлт дүгнэлт гаргах.</p> <ul style="list-style-type: none"> – Тоног төхөөрөмжийн сонголт

	<ul style="list-style-type: none"> – Түүний хүчин чадлын тооцоолол <p>Зүүн үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг шинэчлэл боловсруулан батлуулах.</p> <ul style="list-style-type: none"> – Зүүн үйлдвэрийн 1,2-р цехийн тоног төхөөрөмжийн бодит хүчин чадалд ТЭЗҮ боловсруулах – Зүүн үйлдвэрийн 3-р цехийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажилд тусгагдсан хүчин чадлаар ТЭЗҮ боловсруулах. <p>Зүүн үйлдвэрийн өнөөгийн нөхцөл байдал нь Улаанбаатар хотын нийт хэрэгцээний хэдэн хувийг хангах боломжийг тодорхойлох</p>
7. Барилга байгууламжуудын мэдээлэл	<p>Одоо баригдсан байгаа:</p> <ul style="list-style-type: none"> – 1-р цехийн үйлдвэрийн барилга – 1-р цехийн бутлуурын барилга – 1-р цехийн барицалдуулагч эдийн агуулах – 1-р цехийн хатаагчийн барилга 2 ширхэг – 1-р цехийн савлагааны барилга – 2-р цехийн үйлдвэрийн барилга – 2-р цехийн бутлуурын барилга – 2-р цехийн барицалдуулагч эдийн агуулах – 2-р цехийн хатаагчийн барилга 2 ширхэг – 2-р цехийн савлагааны барилга – 3-р цехийн үйлдвэрийн барилга <p>Шинээр төлөвлөж байгаа:</p> <ul style="list-style-type: none"> – Дулааны зуухны барилга – Авто базын барилга – Засвар цахилгааны байр 3ширхэг – 3-р цехийн шигшин ангилах хэсгийн байр – 3-р цехийн савлагааны байр – Спорт заал – Галын машины граж – Хувцас угаах байр
8. Хууль эрх, зүй	<ol style="list-style-type: none"> 1. Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын холбогдох хууль журам, Олон улсын гэрээний хууль эрх зүйтэй хэрхэн уялдаж байгаа талаар дүгнэж, холбогдох стандарт нөхцөлийн шаардлагуудыг хууль эрх зүйн хүлээх үүргийн хувьд бүрэн хангасан байх арга замыг тодорхойлох. 2. Техникийн даалгаврын шаардлага болон гүйцэтгэх ажлын цар хүрээний талаар бүрэн хэмжээний санал ирүүлэх шаардлагатай. 3. Төслийн ажил нь “Тавантолгой түлш” ХХК-ийн хөгжлийн бодлого болон Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн хүрээнд хийгдсэн байна. 4. Шууд болон шууд бус замаар мэргэжлийн яам болон холбогдох төрийн алба, бусад оролцогчдоос уг

	<p>төсөлтэй холбоотойгоор хүлээн авсан бүх төрлийн материал, өөрийн хийсэн болон гуравдагч этгээдийн хийсэн туршилт, шинжилгээний үр дүн, тэдгээрийн хуулбарын нууцыг чандлан хадгална. Дээрх баримт, материалыг зөвхөн уг төслийн үйл ажиллагааны зориулалтаар ашиглана. Нууцлалын итгэмжлэл нь олон нийтийн хэрэглээний зориулалттай нийтлэгдсэн материалд үл хамаарна. Байгууллагын дотоод хэрэгцээнд зориулагдсан материалыг зөвхөн тухайн төслийн зориулалтын дагуу ашиглахыг зөвшөөрнө.</p> <p>5. Тайлан тус бүрийг хэвлэмэл хэлбэрээр монгол хэл дээр 1 хувь, электрон хэлбэрээр 1 хувийг CD болон DVD хэлбэрээр бичиж хүлээлгэн өгнө. Бүх тайлан материалыг Microsoft Office программын сүүлийн үеийн хувилбаруудыг ашиглан бэлтгэнэ (Word, Excel, PowerPoint, MS-Project, г.м). Танилцуулгыг PowerPoint программаар бэлтгэнэ. Бүх төрлийн зургийг AutoCAD программын сүүлийн үеийн хувилбарыг ашиглан бэлтгэнэ. Бичиг баримтын төрлүүд, Хэрэглэх программ (баримтын хэлбэр) Ажлын төлөвлөгөө, тайлан болон бусад бичгээр хүлээлгэн өгөх баримтууд:</p> <ul style="list-style-type: none"> • Тооцооны хүснэгтүүд MS Excel • Хугацааны жагсаалт MS Project • Зурган болон сканердсан баримтууд JPG хэлбэрээр болон зурган хэлбэрээр • Үндсэн эх баримтууд PDF форматаар үзүүлэх (сүүлийн үеийн хувилбараар) • Танилцуулга MS Power Point • Зураг төсөл AutoCAD болон бусад төрлийн программ хангамж <p>– Ажлын файлуудыг зүй ёсоор хадгалах ёстой бөгөөд харилцаа холбоо, уулзалт, хурал чуулган, хүлээлгэн өгсөн мэдээлэл, хүсэлт, анхан шатны болон явцын тайлангууд, төлбөрийн нэхэмжлэх, нэмэлт өөрчлөлт зэрэг гэрээний бичиг баримтууд болон бусад бүх харилцаанд дэлгэрэнгүй, компьютероор боловсруулсан тэмдэглэлийг хөтөлж, хадгалсан байх шаардлагатай. Ажил гүйцэтгэж дуусахад Зөвлөх нь бичиг баримтын бүх архивыг эмх цэгцтэй, зүй ёсоор индексжүүлж, тэмдэглэгээ үүсгэн “Тавантолгой түлш” ХХК-д хүлээлгэн өгөх ёстой.</p>
<p>9. Инженерийн байгууламж, шугам сүлжээний эх үүсвэр, хангамж</p>	<p>Дулаан хангамж:</p> <p>1.Оффис, ахуйн үйлчилгээний бүс (Оффисын барилга, Зоогийн газар, Ажилчдын халуун усны барилга, Ажилчдын амрах байр А корпус, Ажилчдын амрах байр Б корпус), үйлдвэрийн бүс (Үйлдвэрийн барилга А блок, бутлах цехийн хамт, Үйлдвэрийн барилга Б блок, бутлах цехийн хамт, Агуулахын барилга А блок, Агуулахын</p>

	<p>барилга А блок, Савлагааны барилга А блок, Савлагааны барилга А блок, Засварын байр А блок, Засварын байр А блок), нүүрс угаах үйлдвэр, дахин боловсруулах үйлдвэр нэгдсэн дулааны эх үүсвэрээс дулаан хангамжын шугам хоолой татаж холбох.</p> <p>Цэвэр усны хангамж: Налайхын ус хангамжын системд холбох</p> <p>Бохир усан хангамж: Ахуйн бохирыг нэгдсэн цооногт хийж зөөвөрлөх Үйлдвэрийн зориулалттай бохирыг тунгаагуур ашиглан эргүүлэн ашиглах</p> <p>Цахилгаан хангамж: 110/10-кв-ын дэд станц барих</p> <p>Холбоо дохиолол: Шилэн кабель төлөвлөх</p>
10.Боловсруулах хугацаа	
12. Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	“Таван толгой түлш” ХХК
13. Захиалагч байгууллага	“Таван толгой түлш” ХХК